





ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2018 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу

Засгийн газрын III байр

Утас: (976-11-326414)

Факс: (976-11-324518)

Цахим хуудас: www.nso.mn

И-мэйл: information@nso.mn

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.

Улаанбаатар хот, Монгол Улс, 2019 он

АГУУЛГА

I. УДИРТГАЛ.....	5
1.1 Оршил.....	5
1.2 Өрхийн орлого, зарлагыг бүртгэхийн ач холбогдол.....	5
II. ӨРХ, ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ.....	6
2.1 Өрх, хүн амын үндсэн үзүүлэлтүүд.....	6
2.2 Өрхийн сууцны нөхцөл.....	9
III. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО.....	13
3.1 Өрхийн сарын нийт орлого.....	13
3.2 Өрхийн сарын дундаж мөнгөн орлого.....	15
IV. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА.....	19
4.1 Өрхийн сарын нийт зарлага.....	19
4.2 Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага.....	21
V. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН.....	25
5.1 Өрхийн орлого ба өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт.....	25
5.2 Ажил эрхлэлт ба цалингийн орлого.....	26
VI. ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ.....	28
6.1 Өрхийн хэрэглээний зардал.....	28
VII. ТЭГШ БУС БАЙДАЛ.....	30
7.1 Орлогын тэгш бус байдал.....	30
7.2 Өрхийн хэрэглээний зардлын тэгш бус байдал.....	31
VIII. ӨРХИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ БУСАД ОРЛОГЫН НӨЛӨӨ.....	34
8.1 Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өрхийн орлогод үзүүлэх нөлөө.....	34
8.2 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого.....	36
IX. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ.....	38
9.1 Хадгаламж.....	38
9.2 Зээл.....	39

Зурган мэдээллийн жагсаалт

ЗУРАГ 2.1 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ХУВИАР, 2018 ОН.....	6
ЗУРАГ 2.2 ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ХУВИАР, 2017-2018 ОН.....	7
ЗУРАГ 2.3 ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2018 ОН.....	7
ЗУРАГ 2.4 ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2017-2018 ОН.....	8
ЗУРАГ 2.5 АМ БҮЛИЙН БАЙДАЛ, 2017-2018 ОН.....	8
ЗУРАГ 2.6 СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИАР, 2017-2018 ОН.....	9
ЗУРАГ 2.7 СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИАР, СУУРЫШЛААР, 2017-2018 ОН.....	10
ЗУРАГ 2.8 СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИАР, БҮСЭЭР, 2018 ОН.....	11
ЗУРАГ 2.9 ӨРХИЙН МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2018 ОН.....	12
ЗУРАГ 2.10 ӨРХИЙН ЗАРИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2018 ОН.....	12
ЗУРАГ 3.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ТӨГРӨГӨӨР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	13
ЗУРАГ 3.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	14
ЗУРАГ 3.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, БҮСЭЭР.....	14
ЗУРАГ 3.4 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ОРЛОГЫН ТӨРЛӨӨР, УЛСЫН ДУНДЖААР.....	15
ЗУРАГ 3.5 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, УЛСЫН ДУНДЖААР....	15
ЗУРАГ 3.6 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ОРЛОГЫН ТӨРЛӨӨР, ТӨГРӨГӨӨР, БҮСЭЭР, 2018 ОН.....	16
ЗУРАГ 3.7 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2018 ОН.....	16
ЗУРАГ 3.8 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ОРЛОГООР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, УЛСЫН ДУНДЖААР	17
ЗУРАГ 3.9 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ОРЛОГООР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2018 ОН.....	17
ЗУРАГ 3.10 500'001-700'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ОРЛОГОТой ӨРХИЙН ДУНДАЖ ОРЛОГО, УЛСЫН ДУНДЖААР, 2018 ОН.....	18
ЗУРАГ 3.11 900'001-1'100'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ОРЛОГОТой ӨРХИЙН ДУНДАЖ ОРЛОГО, УЛСЫН ДУНДЖААР, 2018 ОН.....	18
ЗУРАГ 4.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, ТӨГРӨГӨӨР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	19
ЗУРАГ 4.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	20
ЗУРАГ 4.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, БҮСЭЭР.....	20
ЗУРАГ 4.4 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, ЗАРЛАГЫН ТӨРЛӨӨР, УЛСЫН ДУНДЖААР.....	21
ЗУРАГ 4.5 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, УЛСЫН ДУНДЖААР..	21
ЗУРАГ 4.6 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, ЗАРЛАГЫН ТӨРЛӨӨР, ТӨГРӨГӨӨР, БҮСЭЭР, 2018 ОН.....	22
ЗУРАГ 4.7 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2018 ОН.....	22
ЗУРАГ 4.8 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ЗАРЛАГААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, УЛСЫН ДУНДЖААР.....	23
ЗУРАГ 4.9 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ЗАРЛАГААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2018 ОН.....	23
ЗУРАГ 4.10 500'001-700'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ЗАРЛАГАТАЙ ӨРХИЙН ДУНДАЖ ЗАРЛАГА, УЛСЫН ДУНДЖААР, 2018 ОН.....	24
ЗУРАГ 4.11 900'001-1'100'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ЗАРЛАГАТАЙ ӨРХИЙН ДУНДАЖ ЗАРЛАГА, УЛСЫН ДУНДЖААР, 2018 ОН.....	24

ЗУРАГ 5.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР, ТӨГРӨГӨӨР	25
ЗУРАГ 5.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР, ХУВИАР.....	26
ЗУРАГ 5.3 АЖИЛТАЙ ХҮНИЙ ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, АЖИЛ ЭРХЭЛДЭГ САЛБАРААР, ТӨГРӨГӨӨР	27
ЗУРАГ 6.1 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ХУВИАР.....	28
ЗУРАГ 6.2 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ, ТӨРЛӨӨР, ТӨГРӨГӨӨР	29
ЗУРАГ 7.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ТӨГРӨГӨӨР, ӨРХИЙН ТООНЫ ТЭНЦҮҮ 5 БҮЛГЭЭР, 2018 ОН	30
ЗУРАГ 7.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨРӨЛ, ТӨГРӨГӨӨР, ӨРХИЙН ТООНЫ ТЭНЦҮҮ 5 БҮЛГЭЭР, 2018 ОН.....	30
ЗУРАГ 7.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2018 ОН	31
ЗУРАГ 7.4 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ӨРХИЙН ТООНЫ ТЭНЦҮҮ 10 БҮЛГЭЭР, ХУВИАР, 2018 ОН.....	32
ЗУРАГ 7.5 ӨРХИЙН ХҮНСНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ХАМГИЙН ЯДУУ БОЛОН ХАМГИЙН ЧИНЭЭЛЭГ БҮЛГЭЭР, ХУВИАР, 2018 ОН	33
ЗУРАГ 7.6 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, СУУРЫШЛААР, ХУВИАР, 2018 ОН.....	33
ЗУРАГ 8.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГОД ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ, УЛСЫН ДУНДЖААР	34
ЗУРАГ 8.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГОД ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2018 ОН	35
ЗУРАГ 8.3 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, УЛСЫН ДУНДЖААР, 2018 ОН.....	36
ЗУРАГ 8.4 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, 2018 ОН	36
ЗУРАГ 8.5 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, БҮСЭЭР, 2018 ОН.....	37
ЗУРАГ 8.6 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАС, ХҮЙСЭЭР, ТӨГРӨГӨӨР, 2018 ОН	37
ЗУРАГ 9.1 ХАДГАЛАМЖТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ	38
ЗУРАГ 9.2 ӨРХИЙН МӨНГӨН ОРЛОГО БА ХАДГАЛАМЖ, ТӨГРӨГӨӨР	38
ЗУРАГ 9.3 ЗЭЭЛТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ.....	39
ЗУРАГ 9.4 ЗЭЭЛИЙН ДАВХЦАЛ, ХУВИАР	40
ЗУРАГ 9.5 ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, СҮҮЛИЙН 12 САРД АВСАН ЗЭЭЛЭЭР, САЯ ТӨГРӨГӨӨР	40
ЗУРАГ 9.6 ЗЭЭЛТЭЙ ӨРХИЙН ОРЛОГО, ТӨГРӨГӨӨР	41
ЗУРАГ 9.7 ЗЭЭЛИЙН НЭГ САРЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ, МЯНГАН ТӨГРӨГӨӨР.....	42

I. УДИРТГАЛ

1.1 Оршил

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-г 1966 оноос эхлэн тасралтгүй явуулж ирсэн бөгөөд 1995, 1998, 2002-2003 онуудад “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-г мөн зохион байгуулж байв.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг улирал тутам явуулах”-аар хуульчилсны дагуу дээрх хоёр судалгааг нэгтгэн тогтмол явуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекст ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай хэрэглээний мэдээллийг гаргах үндсэн зорилготой улс, бүс, суурьшлын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм.

Уг судалгааны 2018 оны үр дүнг нийтийн хүртээл болгох, мэдээллийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулах зорилгоор 2018 оны 01-р сараас 12-р сарыг дуусталх хугацаанд судалгаанд хамрагдсан 16454 өрхийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, энэхүү танилцуулгыг бэлтгэлээ.

1.2 Өрхийн орлого, зарлагыг бүртгэхийн ач холбогдол

ҮСХ-ноос улирал тутам тогтмол явуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)”-нд хамрагдах өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгодог бөгөөд судалгаанд хамрагдсан өрхүүдийн мэдээлэл нь хүн амын амьжиргааг үнэн зөв тодорхойлоход үнэтэй мэдээлэл болдог. Үүнээс гадна судалгаанд хамрагдсан өрхүүд өрхийн орлого, хэрэглээгээ бүртгэж сурснаар дараах ач холбогдолтой юм. Үүнд:

- Өдөр бүрийн тооцоо, төлөвлөлт нь өрхийн эдийн засгийн амжилт болно.
- Өрхийн орлого, зарлагыг тогтмол, сайн бүртгэснээр өрхөд тохиолдох аливаа эрсдэлийг даван туулахад тусална.
- Статистикийн мэдээлэлтэй харьцуулан өөрийн өрхийн орлого, хэрэглээний онцлог, өөрчлөлтийг харж болно.
- Өрхийн орлогоо бодит байдалдаа нийцүүлж зарцуулах, ашиггүй хэрэглээ, үргүй зардлыг багасгах, хуримтлал үүсгэх зэргээр өрхийн эдийн засгийг бэхжүүлэхэд үндсэн материал болж өгдөг.


II. ӨРХ, ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ

Энэ бүлэгт 2018 онд судалгаанд хамрагдсан өрх, хүн амын шинж байдлыг судалгаанд хамрагдагсдын хүйс болон насны бүлэг, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо, сууцны төрөл болон тухайн сууцны төрөл дэх орлого, зардлын хэсгийг товч байдлаар танилцуулж байна.

2.1 Өрх, хүн амын үндсэн үзүүлэлтүүд


2018 оны судалгааны дүнгээр тооцсон хүн амын нас, хүйсийн суваргаас харахад сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэн харагдаж байна. Мөн нийт хүн амын 62.2 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байгаагийн 50.4 хувь нь эрэгтэйчүүд, 49.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 2.1 Хүн амын нас, хүйсийн суварга, хувиар, 2018 он




Нийт хүн амын хүйсийн харьцааг 2017 онтой харьцуулан доорх зурагт харууллаа. Эндээс үзвэл 2018 онд нийт хүн амын 51.5 хувь нь эмэгтэйчүүд, 48.5 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь 2017 оны дүнгээс эмэгтэйчүүдийн хувьд 0.3 пунктээр буурсан, эрэгтэйчүүдийн хувьд 0.3 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 2.2 Хүйсийн харьцаа, хувиар, 2017-2018 он



Судалгааны дүнгээр 2018 онд нийт хүн амын дотор 0-14 насны хүүхэд 32.4 хувийг эзэлж байгаагаас, эрэгтэйчүүдийн 34.7 хувь, эмэгтэйчүүдийн 30.2 хувийг эзэлж байна (Зураг 2.3). 15-49 насны хүн ам нийт хүн амын 49.6 хувийг эзэлж байгаагаас эрэгтэйчүүдийн 49.4 хувь, эмэгтэйчүүдийн 49.8 хувийг, 50-аас дээш насны хүн ам нийт хүн амын 18.0 хувийг эзэлж байгаагаас эрэгтэйчүүдийн 15.9 хувь, эмэгтэйчүүдийн 20.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2.3 Хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2018 он




18-аас дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг огт гэрлээгүй, гэрлэсэн (батлуулсан, батлуулаагүй), тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн гэсэн 6 бүлэгт хуваан авч үзэхэд 2018 оны байдлаар 18-аас дээш насны хүн амын 60.7 хувь нь гэрлэсэн, 26.3 хувь нь огт гэрлээгүй байна. Гэрлэлтээ цуцалсан хүн амын эзлэх хувь 2017 оныхоос 0.3 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 2.4 Гэрлэлтийн байдал, 2017-2018 он



Өрхийн ам бүлийн бүтцийг Зураг 2.5-д харуулж байна. 2018 оны байдлаар нийт өрхийн 12.7 хувь нь ганц бие өрх байгаа бол 3-4 ам бүлтэй өрхүүд 42.2 хувийг эзэлж байна. 5 ба түүнээс дээш ам бүлтэй өрх нийт өрхийн 28.1 хувийг эзэлж байгаа нь сүүлийн нэг жилийн хугацаанд 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Ам бүлийн дундаж тоо 2018 онд 3.6 байгаа нь 2017 оныхоос өөрчлөгдөөгүй хэвээр байна.

Зураг 2.5 Ам бүлийн байдал, 2017-2018 он



2.2 Өрхийн сууцны нөхцөл

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл цуглуулалтад орон сууцны төрлийг уламжлалт сууц буюу гэр, орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, оюутан, сурагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр, зориулалтын бус сууц болон бусад сууц гэсэн 9 сууцны төрлөөр тодорхойлон өрхөөс асуудаг. Энэхүү танилцуулгад сууцны төрлүүдээс хамгийн түгээмэл сууц¹-ны төрлийг сонгон авч, зарим бага тархалттай хариултуудыг нэгтгэх байдлаар танилцуулж байна. Улсын дунджаар 2018 онд нийт өрхийн 38.6 хувь нь гэрт, 25.6 хувь нь тохилог сууцанд, 33.8 хувь нь байшинд, 2.0 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.


Зураг 2.6 Сууцны төрөл, өрхийн эзлэх хувиар, 2017-2018 он



Амьдралын хэв маяг, дэд бүтэц зэргээс хамаарч өрхийн амьдарч буй сууцны хэлбэр бүс, суурьшлаар харилцан адилгүй байдаг. Тухайлбал Улаанбаатар хотын өрхүүдийн 22.9 хувийг гэрт, 42.2 хувийг тохилог сууцанд, 32.9 хувийг байшинд, 2.0 хувийг бусад сууцанд амьдардаг өрхүүд тус тус эзэлж байна. Харин хөдөө орон нутгийн өрхийн дийлэнх буюу 82.1 хувийг гэрт амьдардаг өрхүүд эзэлдэг бол 1.2 хувийг тохилог сууцанд амьдардаг өрх, 16.1 хувийг байшинд амьдардаг өрх, 0.6 хувийг бусад сууцанд амьдардаг өрх эзэлж байна.


¹ Манай улсын уламжлалт сууц болох гэрийг аль нэг сууцны төрөлтэй нэгтгээгүй буюу гэр, харин орон сууцны байшинг тохилог сууц, байшин гэдэгт сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууцыг хамтатгасан. Бусад сууцны төрөлд оюутан, сурагч, ажилчдын нийтийн байрууд ба зориулалтын бус бусад бүх төрлийн сууцыг оруулсан болно.

Зураг 2.7 Сууцны төрөл, өрхийн эзлэх хувиар, суурьшлаар, 2017-2018 он



Нийт өрхүүдийг бүс дотор нь (Баруун, Хангай, Төв, Зүүн бүсийг авч үзсэн, Улаанбаатар хотыг оруулаагүй) сууцны төрлөөр харьцуулахад гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь Баруун бүсэд (56.5 хувь) хамгийн их, Төвийн бүсэд (43.3 хувь) хамгийн бага байна. Байшинд амьдардаг өрхийн хувьд бүс тус бүрт төдийлөн их ялгаа ажиглагдахгүй байна.

Зураг 2.8 Сууцны төрөл, өрхийн эзлэх хувиар, бүсээр, 2018 он




Өрхийн мөнгөн орлогыг сууцны төрлөөр задлан харахад гэрт амьдардаг өрхийн мөнгөн орлогын 41.3 хувийг цалин хөлсний орлого, 29.5 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 22.8 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 6.4 хувийг бусад орлого эзэлдэг байна. Харин тохилог сууцанд амьдардаг өрхийн мөнгөн орлогын 61.6 хувийг цалин хөлсний орлого, 14.4 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 10.1 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 13.9 хувийг бусад орлого эзэлдэг байна.

Түүнчлэн 2017 онтой харьцуулахад гэрт амьдардаг өрхийн мөнгөн орлого 2018 онд 770.8 мянган төгрөг болж, 20.1 хувиар, тохилог сууцанд амьдардаг өрхийн мөнгөн орлого 1.6 сая төгрөг болж, 12.9 хувиар, байшинд амьдардаг өрхийн мөнгөн орлого 1.1 сая төгрөг болж, 14.1 хувиар, бусад сууцанд амьдардаг өрхийн мөнгөн орлого 1.1 сая төгрөг болж, 22.5 хувиар тус тус өссөн байна.


Сууцны аль ч төрөлд цалин хөлсний орлого дийлэнх хувийг эзэлж байгаа бол гэрт амьдардаг өрхийн хувьд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, тэтгэвэр, тэтгэмжийн орлого мөн өндөр хувийн жинтэй байна.

Зураг 2.9 Өрхийн мөнгөн орлогын бүтэц, сууцны төрлөөр, 2018 он



Өрхийн амьдарч буй сууцны төрөл хэрэглээний зардалд нь хэрхэн нөлөөлж байгааг судлахаар цахилгаан, түлш, орон сууцны төлбөр, тээврийн үйлчилгээ, харилцаа холбооны зардлыг авч үзлээ. Харилцаа холбоо, тээврийн үйлчилгээ, цахилгааны зардал тохилог сууцанд амьдардаг өрхийн хувьд хамгийн их, гэрт амьдардаг өрхийн хувьд хамгийн бага байна. Түлшний зардал байшинд амьдардаг өрхийн хувьд хамгийн өндөр, тохилог сууцны өрхүүдэд хамгийн бага байна.

Зураг 2.10 Өрхийн зарим хэрэглээний зардал, сууцны төрлөөр, 2018 он



Нэг өрх 2018 оны байдлаар сард дунджаар цахилгааны зардалд 21.0 мянган төгрөг, түлшний зардалд 21.2 мянган төгрөг, орон сууцны төлбөрт 25.3 мянган төгрөг, тээврийн үйлчилгээнд 21.1 мянган төгрөг, харилцаа холбоонд 38.4 мянган төгрөг тус тус зарцуулж байна.


III. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

3.1 Өрхийн сарын нийт орлого

Нэг өрхийн сарын дундаж орлого улсын дунджаар 2018 онд 1.2 сая төгрөг болж, 2017 оныхоос 145.6 (14.1%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

2018 онд хотод нэг өрхийн сарын дундаж орлого өмнөх оноос 163.6 (14.6%) мянган төгрөг, хөдөөд 112.6 (12.7%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн орлогыг хооронд нь харьцуулбал, 2018 онд хотын нэг өрхийн сарын дундаж орлого хөдөөгийнхөөс 283.0 (28.3%) мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь өмнөх оноос 51.0 мянган төгрөг буюу 2.1 пунктээр өссөн байна (Зураг 3.1).


Зураг 3.1 Нэг өрхийн сарын дундаж орлого, төгрөгөөр, хот, хөдөөгөөр



Улсын дунджаар нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2018 онд 91.7 хувь болж өмнөх оноос 1.3 пунктээр өсч, бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 4.7 болж 0.6 пункт, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 3.6 болж, 0.7 пунктээр буурсан байна.


Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2018 онд өмнөх оноос хотод 0.3 пункт, хөдөөд 3.2 пунктээр өсч, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.2 пункт, хөдөөд 1.2 пунктээр, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.1 пункт, хөдөөд 2.0 пунктээр буурсан байна (Зураг 3.2).

Зураг 3.2 Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр



Нэг өрхийн сарын дундаж орлогыг бүсээр гарган өмнөх онтой харьцуулбал, 2018 онд Баруун бүсэд 67.7 (7.0%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 127.4 (14.8%) мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 108.2 (10.8%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 212.0 (26.6%) мянган төгрөгөөр, Улаанбаатар хотод 179.3 (15.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 3.3).


Зураг 3.3 Нэг өрхийн сарын дундаж орлого, бүсээр



3.2 Өрхийн сарын дундаж мөнгөн орлого


Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2018 онд улсын дунджаар 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 146.2 (15.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг задалвал, цалин хөлсний орлого өмнөх оноос 60.7 (11.7%) мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 27.7 (15.2%) мянган төгрөгөөр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 31.7 (20.7%) мянган төгрөгөөр, бусад орлого 26.0 (31.2%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 3.4).

Зураг 3.4 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, орлогын төрлөөр, улсын дунджаар




Мөнгөн орлогын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, 2018 онд улсын дунджаар цалин хөлсний орлогын эзлэх хувь 1.8 пункт, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 0.1 пунктээр буурч, харин өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 0.7 пункт, бусад орлогын эзлэх хувь 1.2 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 3.5).

Зураг 3.5 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, улсын дунджаар




Өрхийн мөнгөн орлогыг төрлөөр нь бүсээр задлан харвал, цалингийн орлого Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 817.8 мянган төгрөг байгаа бол Баруун бүсэд хамгийн бага 340.8 мянган төгрөг байна.

Зураг 3.6 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, орлогын төрлөөр, төгрөгөөр, бүсээр, 2018 он




Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2018 онд хотын өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 60.1 хувийг цалин хөлсний орлого дангаараа бүрдүүлж байгаа бол хөдөөгийн өрхийн хувьд цалин хөлс болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого нийлээд 69.5 хувийг бүрдүүлж байна (Зураг 3.7).

Зураг 3.7 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, хот, хөдөөгөөр, 2018 он




Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзвэл, улсын дунджаар 300.0 мянган төгрөг хүртэлх орлоготой өрх 2018 онд өмнөх оноос 3.9 пункт, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 2.3 пункт, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрх 2.7 пункт, 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 0.6 пунктээр буурч, харин 900.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрх 9.5 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 3.8).

Зураг 3.8 Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, дүнд эзлэх хувь, улсын дунджаар




Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн хот, хөдөөгөөр авч үзвэл, хотын өрхүүдийн 16.4 хувь, хөдөөгийн өрхүүдийн 35.4 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэл орлоготой байхад, хотын 56.8 хувь, хөдөөгийн 32.6 хувь нь 900.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байна (Зураг 3.9).

Зураг 3.9 Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2018 он




Сард дунджаар 500.0-700.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 39.0 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 37.8 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 12.2 хувь, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 5.1 хувь, бусад орлого 5.9 хувийг эзэлж байна (Зураг 3.10).

Зураг 3.10 500'001-700'000 төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлого, улсын дунджаар, 2018 он



Мөн сард дунджаар 900.0-1100.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 55.3 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 23.5 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 8.7 хувь, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 6.3 хувь, бусад орлого 6.2 хувийг эзэлж байна (Зураг 3.11).

Зураг 3.11 900'001-1'100'000 төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлого, улсын дунджаар, 2018 он



IV. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА


4.1 Өрхийн сарын нийт зарлага

2018 оны дүнгээр өрхийн сарын дундаж зарлага улсын дунджаар 1.2 сая төгрөг болж, 2017 оныхоос 148.3 (13.6%) мянган төгрөгөөр өссөн байна.

Нэг өрхийн сарын дундаж зарлагыг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2018 онд хотод нэг өрхийн сарын дундаж зарлага өмнөх оноос 169.6 (14.7%) мянган төгрөгөөр, хөдөөд 109.6 (11.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хот, хөдөөгийн зарлагыг хооронд нь харьцуулбал, 2018 онд хотын нэг өрхийн сарын дундаж зарлага хөдөөгийнхөөс 224.3 (20.5%) мянган төгрөгөөр илүү буюу энэ нь өмнөх оноос 59.9 мянган төгрөг буюу 3.8 пунктээр өссөн байна (Зураг 4.1).


Зураг 4.1 Нэг өрхийн сарын дундаж зарлага, төгрөгөөр, хот, хөдөөгөөр



Улсын дунджаар нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2018 онд 92.0 хувь болж өмнөх оноос 1.1 пунктээр өсч, бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 4.5 хувь болж 0.5 пункт, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 3.5 хувь болж 0.6 пунктээр буурсан байна.


Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2018 онд өмнөх оноос хотод 0.3 пункт, хөдөөд 2.6 пунктээр өсч, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.2 пункт, хөдөөд 0.9 пунктээр, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.1 пункт, хөдөөд 1.7 пунктээр буурсан байна (Зураг 4.2).

Зураг 4.2 Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр



Бүсээр нэг өрхийн сарын дундаж зарлагыг өмнөх онтой харьцуулбал, 2018 онд Баруун бүсэд 15.1 (1.3%) мянган төгрөг, Хангайн бүсэд 127.6 (13.4%) мянган төгрөг, Төвийн бүсэд 130.8 (12.1%) мянган төгрөг, Зүүн бүсэд 222.1 (25.3%) мянган төгрөг, Улаанбаатар хотод 189.1 (15.9%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 4.3).


Зураг 4.3 Нэг өрхийн сарын дундаж зарлага, бүсээр



4.2 Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага


Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2018 онд улсын дунджаар 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 149.0 (15.0%) мянган төгрөгөөр өссөн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг задалбал, хүнсний зүйлийн зарлага өмнөх оноос 20.8 (9.1%) мянган төгрөгөөр, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 123.4 (16.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 4.4).

Зураг 4.4 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, зарлагын төрлөөр, улсын дунджаар




Мөнгөн зарлагын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, 2018 онд улсын дунджаар хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь 1.2 пунктээр буурч, бусдад өгсөн бэлэг, тусламжийн эзлэх хувь 0.1 пункт, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлагын эзлэх хувь 1.1 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 4.5).

Зураг 4.5 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц, улсын дунджаар




Зураг 4.6 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, зарлагын төрлөөр, төгрөгөөр, бүсээр, 2018 он




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2018 онд хотын өрх сарын дундаж мөнгөн зарлагынхаа 74.7 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд, 23.4 хувийг хүнсний зүйлд зарцуулж байгаа бол хөдөөгийн өрхийн хувьд хүнсний бус бараа, үйлчилгээнд 79.0 хувийг, хүнсний зүйлд 17.7 хувийг зарцуулж байна (Зураг 4.7).

Зураг 4.7 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц, хот, хөдөөгөөр, 2018 он




Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзвэл, улсын дунджаар 300.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай өрх 2018 онд өмнөх оноос 2.3 пункт, 300.0-500.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 3.0 пункт, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 2.8 пункт, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 1.1 пунктээр буурч, харин 900.0 мянган төгрөгөөс дээш зарлагатай өрх 9.2 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 4.8).

Зураг 4.8 Өрхийн бүлэглэлт, мөнгөн зарлагаар, дүнд эзлэх хувь, улсын дунджаар




Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн хот, хөдөөгөөр авч үзвэл, хотын өрхүүдийн 14.7 хувь, хөдөөгийн өрхүүдийн 30.0 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэл зарлагатай, харин хотын өрхүүдийн 58.5 хувь, хөдөөгийн 39.6 хувь нь 900.0 мянган төгрөгөөс дээш зарлагатай байна (Зураг 4.9).

Зураг 4.9 Өрхийн бүлэглэлт, мөнгөн зарлагаар, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2018 он




Сард дунджаар 500.0-700.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний зүйлийн зарлага 30.5 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 54.4 хувь, бусад зарлага 13.3 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 1.8 хувийг эзэлж байна (Зураг 4.10).

Зураг 4.10 500'001-700'000 төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлага, улсын дунджаар, 2018 он



Сард дунджаар 900.0-1100.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний зүйлийн зарлага 25.5 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 61.5 хувь, бусад зарлага 11.2 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 1.8 хувийг эзэлж байна (Зураг 4.11).

Зураг 4.11 900'001-1100'000 төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлага, улсын дунджаар, 2018 он



V. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН

5.1 Өрхийн орлого ба өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлын талаарх үзүүлэлт юм. Өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал өрхийн орлогод хэрхэн нөлөөлж буйг дараах зургаар харуулж байна.

Зураг 5.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар, төгрөгөөр




2018 оны байдлаар өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 1.2 сая төгрөг байгаа нь өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй өрхөөс 49.4 хувиар, өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур байдаг өрхөөс 45.8 хувиар дээгүүр байгаа бөгөөд 2017 оны дүнгээс 14.6 хувиар өсжээ.

2018 оны байдлаар өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 59.9 хувь нь цалин хөлсний орлого, 10.9 хувь нь ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 10.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 9.9 хувь нь ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 9.3 хувь нь бусад орлогоос бүрдэж байна (Зураг 5.2).

Өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур бол тухайн өрхийн орлогын дийлэнхийг буюу 64.6 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна.

Зураг 5.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар, хувиар



Өрхөд байгаа ажилтай хүний тоо 2018 онд дунджаар 1.4 байна. Энэ үзүүлэлт 2010-2012 онд 1.5, 2014 онд 1.4, 2016-2017 онд 1.3 байжээ.

5.2 Ажил эрхлэлт ба цалингийн орлого

Улсын дунджаар 2018 онд нэг өрхөд ноогдох дундаж цалингийн хэмжээ оны үнээр 577.8 мянган төгрөг байна (Хүснэгт 5.1). Энэ нь өмнөх онтой харьцуулахад 11.7 хувиар өссөн үзүүлэлт юм.


Хүснэгт 5.1 Өрхийн дундаж цалингийн хэмжээ, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхэлдэг салбараар, төгрөгөөр

	Цалингийн дундаж хэмжээ		Цалингийн голч	
	2017	2018	2017	2018
Улсын дундаж	517 121	577 813	380 000	400 000
Ажилтай: Нийт	655 801	720 924	500 000	570 000
Хөдөө аж ахуй	103 634	125 820	-	-
Аж үйлдвэр	920 788	1 041 206	800 000	900 000
Үйлчилгээ	804 360	847 955	660 000	700 000

Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн дундаж цалин 720.9 мянган төгрөг байна. Үүнээс хөдөө аж ахуйн салбарт өрхийн тэргүүлэгч нь ажиллаж байгаа өрхийн дундаж цалин хамгийн бага, аж үйлдвэрийн салбарт ажилладаг өрхийн тэргүүнтэй өрхийн дундаж цалин хамгийн өндөр 1.0 сая төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 13.1 хувиар өсжээ. Цалингийн голч хэмжээ дундаж хэмжээтэйгээ харьцуулахад 126-178 орчим мянган төгрөгөөр бага байгаа нь цалингийн тархалт жигд биш буюу өндөр цалинтай цөөн хүн, бага цалинтай олон хүн нийгэмд байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл 2018 оны байдлаар нийт өрхийн 50 хувь нь 400 мянгаас бага цалинтай, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн тал хувь нь 570 мянгаас доош цалин авч байна. Аж үйлдвэрийн салбарт энэ ялгаа илүү тод ажиглагдлаа.

Цалингийн хэмжээг зөвхөн ажилтай хүний дунджаар шинжилсэнийг Зураг 5.3-т харуулав. Улсын дунджаар 2018 онд ажилтай нэг хүнд ногдох дундаж цалингийн хэмжээ оны үнээр 422.4 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 8.0 хувиар өсжээ. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний цалин хамгийн бага 37.2 мянган төгрөг, аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа хүний дундаж цалин хамгийн өндөр, 647.5 мянган төгрөг байна.

Зураг 5.3 Ажилтай хүний цалингийн хэмжээ, ажил эрхэлдэг салбараар, төгрөгөөр




VI. ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ

6.1 Өрхийн хэрэглээний зардал

Өрхийн хэрэглээний зардал нь хоол хүнс, хувцас, байр халаалтын төлбөр болон жижиг зардал зэрэг шууд хэрэглээ болдог, тухайн өрх ахуйн хэрэглээндээ зориулан худалдаж авч буй эд зүйл, үйлчилгээний төлбөр юм. Энэхүү танилцуулгад хэрэглээний зардлыг хүнсний зардал, хүнсний бус зардал, архи согтууруулах ундаа, тамхины зардал гэж хуваан авч үзлээ. Улсын дунджаар 2018 онд өрхийн хэрэглээний зардал сард 934.1 мянган төгрөг байгаа бол хотод 1.0 сая төгрөг, хөдөөд 775.9 мянган төгрөг байна. Бүсээр хэрэглээний зардлыг авч үзвэл, Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 1.1 сая төгрөг, Баруун бүсэд 885.5 мянган төгрөг, Төвийн бүсэд 836.8 мянган төгрөг, Хангайн бүсэд 779.3 мянган төгрөг, Зүүн бүсэд хамгийн бага буюу 765.3 мянган төгрөг байна.

Өрхийн хэрэглээний зардлын бүтцэд дийлэнх хэсгийг буюу 65.6 хувийг хүнсний бус зардал, 33.0 хувийг хүнсний зардал эзэлж байхад согтууруулах ундаа, тамхины зардал 1.4 хувийг эзэлж байна.

Зураг 6.1 Өрхийн хэрэглээний зардлын бүтэц, хувиар, 2018 он



Нэг өрхийн сард хэрэглэдэг хүнсний зарим зардлыг дунджаар тооцож үзвэл, 110.4 мянган төгрөгийг мах, махан бүтээгдэхүүнд, 64.8 мянган төгрөгийг гурил, гурилан бүтээгдэхүүнд, 43.7 мянган төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүнд зарцуулдаг байна.

Хүнсний бус зардлыг тооцвол, 101.1 мянган төгрөгийг бэлэн хувцасны зардалд, 88.8 мянган төгрөгийг тээврийн үйлчилгээний зардалд, 70.5 мянган төгрөгийг эмнэлгийн үйлчилгээний зардалд, 55.1 мянган төгрөгийг боловсролын зардалд, 37.5 мянган төгрөгийг сууц, түрээсийн зардалд зарцуулжээ (Зураг 6.2).

Зураг 6.2 Өрхийн хэрэглээний зардал, төрлөөр, төгрөгөөр, 2018 он




VII. ТЭГШ БУС БАЙДАЛ

7.1 Орлогын тэгш бус байдал


Мөнгөн орлогыг өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр хувааж үзвэл, хамгийн ядуу хэсгийн мөнгөн орлого улсын дунджаас 3.3 дахин бага, хамгийн чинээлэг хэсгийн мөнгөн орлого 2.2 дахин их байна. Хамгийн чинээлэг хэсгийн сарын дундаж мөнгөн орлого ядуу хэсгээс 7.1 дахин их байна.

Зураг 7.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2018 он




Өрхийн орлого нэмэгдэх тусам орлого өндөртэй бүлгүүдийн хувьд цалингийн орлогын эзлэх хувь өсч байгаа нь ядуу бус өрхийн гишүүдийн ажил эрхлэх боломж ядуу өрхийнхөөс арай илүү байж болохыг харуулж байна. Тодруулбал улсын дунджаар хамгийн чинээлэг бүлэг хамгийн ядуу бүлгийнхнээс 12.7 дахин өндөр цалинтай байна.

Зураг 7.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын төрөл, төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2018 он



Хамгийн ядуу хэсгийн мөнгөн орлогын дийлэнх буюу 46.9 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа бол хамгийн чинээлэг хэсгийн хувьд тэдний сарын дундаж мөнгөн орлогын 9.9 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байна. Эндээс ядуу өрхийн амьжиргаанд тэтгэвэр, тэтгэмжийн үзүүлэх нөлөө нэлээд их байдаг нь харагдаж байна.


Зураг 7.3 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, 2018 он



7.2 Өрхийн хэрэглээний зардлын тэгш бус байдал


Өрхийн хэрэглээний зардлыг өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр харвал, хамгийн ядуу хэсгийн хэрэглээний зардал нь хамгийн чинээлэг хэсгийнхээс 2018 онд 6.0 дахин бага байна. Хамгийн ядуу өрхийн хэрэглээний зардлын 45.3 хувь буюу бараг талыг нь хүнсний зардал эзэлж байхад хамгийн чинээлэг хэсгийн хэрэглээний зардлын 73.8 хувийг хүнсний бус зүйлийн зардал эзэлж байна. Зардлын бүтцээс харахад өрхүүд чинээлэг болох тусам хүнсний бус зүйлд зарцуулах хувь, өрхүүд ядуу болох тусам хүнсэндээ зарцуулах зардлын хувь нь өсөж байгаа зүй тогтол харагдаж байна (Зураг 7.4).

Зураг 7.4 Өрхийн хэрэглээний зардлын бүтэц, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр, хувиар, 2018 он




Хамгийн ядуу бүлгийн өрхийн хүнсний зардлын 44.6 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 24.8 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн, 11.8 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүний зардал эзэлж байгаа бол хамгийн чинээлэг өрхийн хүнсний зардлын 30.3 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 17.3 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн, 13.7 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүний зардал эзэлж байна. Мөн чинээлэг өрхийн зоогийн газар, гадуур хооллосон зардал нийт хүнсний хэрэглээний зардлын 14.1 хувийг эзэлж байхад ядуу өрхийн хувьд 2.9 хувьтай байна.

Зураг 7.5 Өрхийн хүнсний зардлын бүтэц, хамгийн ядуу болон хамгийн чинээлэг бүлгээр, хувиар, 2018 он



Өрхийн хэрэглээний зардлын бүтцийг бүс, суурьшлаар авч үзвэл, хүнсний зардлын эзлэх хувь хөдөөд болон Зүүн бүсэд хамгийн өндөр байна.

Зураг 7.6 Өрхийн хэрэглээний зардлын бүтэц, бүс, суурьшлаар, хувиар, 2018 он




VIII. ӨРХИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ БУСАД ОРЛОГЫН НӨЛӨӨ

8.1 Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өрхийн орлогод үзүүлэх нөлөө

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого улсын дунджаар 1.1 сая төгрөг болж, үүний 210.2 (19.4%) мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 27.7 (15.2%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувийг авч үзвэл, 2018 онд нийгмийн даатгалын сангийн өндөр насны тэтгэвэр 130.8 (12.1%) мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 16.4 (1.5%) мянган төгрөг, нийгмийн халамжийн сангийн хүүхдийн мөнгө 21.8 (2.0%) мянган төгрөгийг эзэлж байна (Зураг 8.1).


Зураг 8.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь, улсын дунджаар



Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг хот, хөдөөгөөр авч үзвэл, нэг өрхийн сарын дундаж тэтгэвэр, тэтгэмжийн орлого 2018 онд хотод 223.3 мянган төгрөг болж өмнөх оноос 28.0 (14.3%) мянган төгрөгөөр, хөдөөд 186.5 мянган төгрөг болж өмнөх оноос 27.3 (17.2%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь хөдөөгийн өрхүүдийн амьжиргаанд илүү хувь нэмэр оруулж байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь хотод 18.3 хувь, хөдөөд 22.5 хувийг эзэлж байна. Үүнээс нийгмийн даатгалын сангийн өндөр настны тэтгэврийн эзлэх хувь хотод 11.8 хувь, хөдөөд 12.9 хувь байна.

Зураг 8.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2018 он



8.2 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгаагаар нийт өрхийн 13.4 хувь нь хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаагаас худалдааны чиглэлээр 42.7 хувь, тээвэрлэлтийн чиглэлээр 22.3 хувь, үйлдвэрлэлийн чиглэлээр 15.2 хувь нь үйл ажиллагаа явуулж байна (Зураг 8.3).

Зураг 8.3 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэлт, үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар, 2018 он




Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн хувьд нэг өрхийн сарын дундаж орлогыг үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 2018 оны байдлаар барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого 949.9 мянган төгрөг, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого 870.0 мянган төгрөг, зочид буудал, ресторан, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого 618.7 мянган төгрөг байна (Зураг 8.4).

Зураг 8.4 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, үйл ажиллагааны салбараар, 2018 он




Мөн бүсээр авч үзвэл, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн хувьд өрхийн сарын дундаж орлого Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 795.7 мянган төгрөг, Баруун бүсэд хамгийн бага буюу 520.4 мянган төгрөг байна (Зураг 8.5).

Зураг 8.5 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, бүсээр, 2018 он



Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн насаар нь ангилж үзвэл, өрхийн тэргүүлэгч нь 40-49 настай өрхийн сарын дундаж орлого 795.1 мянган төгрөг буюу бусад насны тэргүүлэгчдийг бодвол хамгийн өндөр, өрхийн тэргүүлэгч нь 60-аас дээш настай өрхийн сарын дундаж орлого бусад насны тэргүүлэгчтэй өрхөөс бага байна (Зураг 8.6).

Зураг 8.6 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсээр, төгрөгөөр, 2018 он




Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзвэл, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлого эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлогоос 99.4 (16.5%) мянган төгрөгөөр илүү байна (Зураг 8.6).

IX. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

9.1 Хадгаламж

Монгол Улсын нийт өрхийн 23.7 хувь нь 2018 оны байдлаар хадгаламжтай байна. Хадгаламжтай өрхийн хувь 2017 оноос 2018 онд 1.9 пунктээр нэмэгджээ.

Зураг 9.1 Хадгаламжтай өрхийн эзлэх хувь



Хадгаламжгүй нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2018 онд 936.7 мянган төгрөг болж, өмнөх оныхоос 119.5 (14.6%) мянган төгрөгөөр, хадгаламжтай өрхийнх 1.6 сая төгрөг болж өмнөх оныхоос 189.1 (13.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.


Зураг 9.2 Өрхийн мөнгөн орлого ба хадгаламж, төгрөгөөр



9.2 ЗЭЭЛ

Монгол Улсын нийт өрхийн 52.1 хувь нь 2017 онд ямар нэгэн зээлтэй² байсан бол 2018 оны байдлаар нийт өрхийн 55.8 хувь нь буюу 498.0 мянган өрх зээлтэй амьдарч байна. Үүнээс: нийт өрхийн 23.0 хувь нь буюу 205.3 мянган өрх цалингийн зээлтэй, 14.4 хувь нь буюу 128.5 мянган өрх тэтгэврийн зээлтэй, 7.9 хувь нь буюу 70.5 мянган өрх малчны зээлтэй, 6.7 хувь нь буюу 59.8 мянган өрх орон сууцны зээлтэй байна.


Зураг 9.3 Зээлтэй өрхийн эзлэх хувь



Нэг өрх хэд хэдэн зээлтэй байх тохиолдол нэлээдгүй байна. Тухайлбал, тухайн өрхөд ажил хийдэг хоёр хүн хоёулаа цалингийн зээлтэй байх, тэтгэврийн хоёр ахмад настан хоёулаа тэтгэврийн зээлтэй байх, эсвэл өрхийн нэг гишүүн нь цалингийн зээлтэй байхад нөгөөх нь лизингийн зээлтэй байх гэх мэт олон тохиолдлууд байна. Зээлийн давхцалыг тооцохдоо өрхөд ижил төрлийн зээл олон байгаа тохиолдолд нэг зээл болгон нэгтгэж авсан бөгөөд өөр төрлийн зээл байгаа тохиолдолд давхар зээлтэй гэж үзсэн. Дараах зурагт өрхийн 3 хүртэлх төрлийн зээлийн давхцалыг харууллаа.

² Өрхийг хэдэн төрлийн зээлтэй байхаас нь үл хамааруулан ямар нэгэн зээлтэй бол тухайн өрхийг зээлтэй өрх гэж тооцсон.


Зураг 9.4 Зээлийн давхцал, хувиар



2017 оны байдлаар зээлтэй өрхүүдийн 83.7 хувь нь зөвхөн нэг төрлийн зээлтэй, 14.7 хувь нь 2 төрлийн зээлтэй, 1.6 хувь нь 3 төрлийн давхар зээлтэй байсан бол 2018 онд зээлтэй өрхүүдийн 81.8 хувь нь нэг төрлийн зээлтэй, 16.2 хувь нь 2 төрлийн зээлтэй, 2.0 хувь нь 3 төрлийн зээлтэй байна.


Зээлтэй өрхүүдийн сүүлийн 12 сард авсан зээлийн хэмжээг доорх зурагт харуулж байна. 2018 онд зээлтэй нэг өрх дунджаар 6.8 сая төгрөгийн зээл авчээ. Орон сууцны зээлийн дундаж хэмжээ 41.7 сая төгрөг, автомашины зээлийн дундаж хэмжээ 15.3 сая төгрөг, бизнесийн зээлийн дундаж хэмжээ 14.2 сая төгрөг, цалингийн зээлийн дундаж хэмжээ 6.7 сая төгрөг, өрхийн хэрэглээний зээлийн дундаж хэмжээ 4.5 сая төгрөг, малчны зээлийн дундаж хэмжээ 3.9 сая төгрөг, тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 3.3 сая төгрөг байна.

Зураг 9.5 Зээлийн хэмжээ, сүүлийн 12 сард авсан зээлээр, сая төгрөгөөр



Зээлтэй өрхийн орлогыг судалж үзвэл 2018 онд зээлтэй нэг өрхийн сарын дундаж орлого 1.2 сая төгрөг болж, 2017 оноос 148.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Орлогын төрлөөр харвал 2018 онд зээлтэй өрхийн цалингийн орлого 664.0 мянган төгрөг, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 214.8 мянган төгрөг, ХАА-н орлого 101.5 мянган төгрөг, ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 101.8 мянган төгрөг, бусад орлого 123.5 мянган төгрөг байна.

Зураг 9.6 Зээлтэй өрхийн орлого, төгрөгөөр



Зээлийн эргэн төлөлтийг харвал зээлтэй нэг өрх 2018 оны байдлаар сард 508.1 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтөнд буцаан төлж байна. Орон сууцны зээлтэй өрх уг зээлэндээ сард дунджаар 560.8 мянган төгрөгийг, цалингийн зээлтэй өрх 408.2 мянган төгрөгийг, тэтгэврийн зээлтэй өрх 330.7 мянган төгрөгийг олсон орлогоосоо буцаан төлж байна.

Зураг 9.7 Зээлийн нэг сарын эргэн төлөлт, мянган төгрөгөөр

